

**ЗХУКН, ЗӨВЛӨЛТ ТӨРИЙН ЭНХ ТАЙВАНЧ ГАДААД БОДЛОГО
БОЛ ХҮН ТӨРӨЛХТНИЙ АМЬДРАХ ЭРХИЙН НАЙДВАРТАЙ
БАТАЛГАА МӨН**

**ЗСБНХУ энх тайвны үйп хэргийг сахин хамгаалах
зориг шийдвэр төгс байна.**

МАХН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга, БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга Ю. Цэдэнбал ЗСБНХУ-аас БНМАУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд С. П. Павловыг өчигдөр (1983 оны 9-р сарын 29-нд ред.) хүлээн авч уулзлаа.

ЗХУКН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга, ЗСБНХУ-ын Дээд Зөвлөлийн Тэргүүлэгчдийн дарга Ю. В. Андроповын энэ оны есдүгээр сарын 28-ны мэдэгдлийг нөхөр Ю. Цэдэнбалд элчин сайд С. П. Павлов гардуулав.

МАХН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга, БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга Ю. Цэдэнбал нөхөр Ю. В. Андроповын маш чухал мэдэгдэлд тодорхойлсон үнэлэлт, дүгнэлтийг бүрэн дүүрэн дэмжиж байгаагаа МАХН-ын Төв Хороо, БНМАУ-ын Засгийн газрын өмнөөс илэрхийллээ. Нөхөр Ю. Цэдэнбал тухайлан өгүүлэхдээ:

ЗХУКН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга, ЗСБНХУ-ын Дээд Зөвлөлийн Тэргүүлэгчдийн дарга нөхөр Юрий Владимирович Андроповын хийсэн мэдэгдлийн агуулгатай бид урьдчилан танилцлаа.

Зөвлөлтийн удирдагчийн энэ цаг үеэ олсон, чухал мэдэгдэлд тодорхойлсон үнэлэлт, дүгнэлтийг бүрэн дүүрэн дэмжиж байгаагаа манай Намын Төв Хороо, Монголын засгийн газрын өмнөөс илэрхийлж байна.

Олон улсын байдал нарийн ээдрээтэй байгаа одоо үед дайн, энхийн асуудалд хандах хоёр өөр хандлага улам ялгаран тодорч байна. Империализмын хүч, юуны өмнө АНУ-ын милитарист бүлгийнхэн стратегийн тэнцвэртэй байдлыг өөртөө ашигтайгаар өөрчлөх, эзэрхэн түрэмгийлэх санаархлаа хэрэгжүүлэхийн тулд бүхий л арга хэрэгслээ олон улсын түгшүүртэй байдлыг хурцатгах, зэвсэглэлээр улам улайран хөөцөлдөж, дэлхий дахинд халз сөргөлдөөнийг гааруулахад зориулан ашиглаж байна.

Энэхүү чиг бодлогын өөдөөс Зөвлөлт Холбоот Улс, социалист хамтын нөхөрлөлийн бусад орон идэвхтэй бөгөөд оновчтой бодлогоо сэргүүлэн тавьж байна. Социалист орнууд хүч чармайлтаа цөмийн дайныг сэрэмжлэн зайлуулах бүх нийтийн энх тайвныг сахин хамгаалах, зэвсэглэлээр хөөцөлдөх хөнөөлт явдлыг хазаарлан зогсоох гэсэн өнөө үеийн гол зорилтыг шийдвэрлэхэд төвлөрүүлж байна.

Нөхөр Ю. В. Андроповын мэдэгдэл нь Зөвлөлт Холбоот Улс энх тайвныг чин үнэнээсээ эрхэмлэн, энх тайван, намжмал байдлыг бэхжүүлэх, улс гүрнүүдийн энх тайван, хамтын ажиллагааг хөгжүүлэхийн төлөө сэтгэл зүрхнээсээ анхаарал санаа тавьж байдгийг дахин нотоллоо.

Энх тайвныг сахин хамгаалж болох бөгөөд Зөвлөлт Холбоот Улс ч империалист, милитарист бүлгийнхний түрэмгий санаархалд хариу няцаалт өгөх зориг шийдвэр төгс байна. Нөхөр Ю. В. Андроповын мэдэгдэлд ийм бат итгэлтэй зориг шийдвэр дүүрэн байна.

Зөвлөлт Холбоот Улсын тууштай санаачилгатай чиг бодлого, энх тайван, улс түмний аюулгүй байдал, хөгжил дэвшлийн үйл хэрэгт оруулж байгаа асар их хувь нэмрийг МАХН-ын Төв Хороо, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар өндөр үнэлж байна.

БНМАУ хүн төрөлхтний энх амгалан ирээдүйн төлөө Зөвлөлт Холбоот Улс болон ах дүү бусад орны хамтаар хойшид ч цуцалтгүй тэмцэх болно гэв.

**ЗХУКН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга,
ЗСБНХУ-ын Дээд Зөвлөлийн Тэргүүлэгчдийн дарга
Юрий Андроповын МЭДЭГДЭЛ**

МОСКВА. Есдүгээр сарын 28. (МОНЦАМЭ).

ЗХУКН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга, ЗСБНХУ-ын Дээд Зөвлөлийн Тэргүүлэгчдийн дарга Юрий Андроповын мэдэгдлийн бүрэн эхийг дор сийрүүлэв.

Олон улсын үйл хэрэгт АНУ-ын одоогийн засаг захиргааны баримтлан явуулж байгаа чиг шугамд өгч байгаа үнэлэлт дүгнэлтээ зөвлөлтийн хүмүүс, бусад ард түмэн, тэрчилэн улс орнуудын бодлогыг тодорхойлох талаар хариуцлага хүлээсэн бүх хүний сонорт хүргэх нь чухал гэж зөвлөлтийн удирдлага үзэж байна.

Товчоор хэлбэл, энэ бол энх тайванд ноцтой аюул занал учруулж байгаа милитарист чиг шугам юм. Бусад улс орон, ард түмний эрх ашгийг үл тоомсорлон, дэлхийд АНУ-ын ноёлох байр суурийг хангахыг оролдох нь энэ чиг шугамын мөн чанар юм.

АНУ-ын цэргийн хүч нөөцийг урьд өмнө үзэгдээгүй ихээр нэмэгдүүлж байгаа явдал, бүх төрлийн зэвсэг, тухайлбал цөмийн болон хими, ердийн зэвсэг үйлдвэрлэх өргөн хүрээтэй программ нь чухамдаа дээрх зорилгод захирагдаж байна. Зэвсэглэлээр ухаан жолоогүй хөөцөлдөх явдлыг АНУ одоо бүр сансарт дэлгэрүүлэхээр төлөвлөж байна.

Санаанаас зохиосон элдэв аян шалтаг заан АНУ-ын нутаг дэвсгэрээс олон мянган километрийн алсад америкийн цэргийн оролцоог өргөжүүлж байна. Зэвсэгт хүч хэрэглэн бусад улсын хэрэгт хөндлөнгөөс шууд оролцох, Вашингтоныхны шахалт тулгалтыг няцааж байгаа аливаа орны эсрэг америкийн зэвсгийг ашиглахын тулд түшиц газрууд байгуулж байна. Энэ бүхний уршгаар дэлхийн бүх нутаг орон, тухайлбал Европ, Ази, Африк, Ойрхи Дорнод, Төв Америкт түгшүүртэй байдал өслөө.

Вашингтоныхон энэ бүх аюултай төлөвлөгөөгөө хэрэгжүүлэхэд НАТО-гийн бусад орныг улам их татан оролцуулж байна. Түүгээр ч барахгүй японы милитаризмыг сэргээж, түүнийг энэ эвслийн цэрэг—улс төрийн машины хавсарга болгохыг чармайж байна. Ингэхдээ тэд өнгөрсөн үеийн сургамжийг албаар мартуулахыг хичээж байна.

Ард түмэн ямарваа засгийн газрын бодлогыг юуны өмнө түүний үйл ажиллагаагаар дүгнэдэг билээ. Иймээс АНУ-ын ерөнхийлөгч энх тайвны үйл хэрэг, улс түмний өөртөө засан тохинох эрх, бүрэн эрхт байдлын үйл хэрэгт үнэнч байдаг тухай НҮБ-ын индрээс хичнээн сүржин мэдэгдэл хийсэн ч ийм мэдэгдэл хэнийг ч ятган итгүүлж чадахгүй.

Хэрэв хэн нэг хүн америкийн одоогийн засаг захиргааны бодлогыг сайн тийш өөрчлөгдөж магадгүй гэж дэмий л итгэж байсан бол сүү-